



ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/40

Улаанбаатар хот

Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1106 дугаар захирамж, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Хэлтсүүдийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах, хяналт шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, урьдчилан сэргийлэх, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх удирдамжийг нэгдүгээр хавсралтаар, дотоод хяналт шалгалтын хуваарийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Батлагдсан удирдамж, хуваарийн дагуу дотоод, хяналт шалгалтыг зохион байгуулж ажлын үр дүнг газрын Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-т даалгасугай.

ДАРГА

С.ТӨМӨРДУЛАМ